Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Б.ЗОЛБООГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт, хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (Биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилго. Салбарын хяналтыг боловсронгуй болгож, хэрэгжүүлэх замаар хүний аюулгүй байдлыг хангаж, эрүүл аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлж хуулийн хэрэгжилтийг хангуулна.** | | | | | | | |
| **Зорилт 1. Салбарын хяналт шалгалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.** | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 1.1.** ТХШТХ-ийн 9.2.1. Орчны эрүүл ахуйн хяналтын чиглэлээр 10.10.10, 10.10.11 кодтой хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулна. | Шинэчлэгдсэн хяналтын хуудас | - | Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулна. | Орчны эрүүл ахуйн хяналтын чиглэлээр 10.10.10, 10.10.11 кодтой 2 хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулж, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/76 дугаар тушаалаар батлуулан хяналт шалгалтыг гүйцэтгэж байна. | 2024.01.02-2024.03.30 | 100 |
| 2 | **Арга хэмжээ 1.2** ЭАТХ-ийн 5.3 Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, барилгын зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг өөрчлөхөд эрүүл ахуйн урьдчилсан хяналт хийх заавар ыг шинэчлэн боловсруулна. | Боловсруулж, батлуулсан заавар | - | Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулна. | Барилга байгууламжийн зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг өөрчлөхөд эрүүл ахуйн хяналт хийхэд улсын байцаагчийн мөрдөх заавар"-ыг шинэчлэн боловсруулж ЭМСайдын 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн А/441 дугаар тушаалаар | 2024.07.01 2024.12.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | батлуулж мөрдөн ажиллаж байна. | | |
| **Зорилт 2. Бодлогын баримт бичиг болон хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 3 | **Арга хэмжээ 2.1.** ТХШТХ-ийн $5^2$.1 Орчны эрүүл ахуйн хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн обьектод төлөвлөгөөт хяналт шалгалт зохион байгуулна. | Обьектын хамралтын хувь | - | 45% | Орчны эрүүл ахуйн хяналтын чиглэлээр 371 обьектод төлөвлөгөөт шалгалт хийхээр төлөвлөснөөс 352 обьектод хяналт шалгалт хийсэн. Гүйцэтгэлийн хувь 95%. | 2024.02.01-2024.05.31 | 100 |
| | **Дэд арга хэмжээ.2.1.1** Төлөвлөгөөт шалгалтын удирдамж боловсруулж, аймаг, нийслэлийн ЭМГ-т хүргүүлнэ. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | 10% | Хүн амын ундны усны эх үүсвэр, зочид буудал, дэн буудал, амралтын газар, аялал жуулчлалын баазад төлөвлөгөөт шалгалт хийх тухай 10-00/24 дугаартай удирдамж боловсруулж хүргүүлсэн. | 2024.02.01-2024.03.01 | |
| | **Дэд арга хэмжээ.2.1.2** Их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 20 обьектод хяналт шалгалт хийнэ. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | 30% | Их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн Архангай аймгийн 16, Сүхбаатар аймгийн 4 нийт 20 обьектод төлөвлөгөөт шалгалт хийж гүйцэтгэсэн. | 2024.04.01-2024.09.30 | |
| | | Обьектын хамралтын хувь | 100% | 100% | Төлөвлөсөн 20 обьектыг бүрэн хамруулсан. | | |
| | **Дэд арга хэмжээ.2.1.3** Төлөвлөгөөт шалгалтын явцын, жилийн эцсийн дүн мэдээг аймаг, нийслэлээс авч нэгдсэн танилцуулга боловсруулна. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | 15% | Төлөвлөгөөт шалгалтын явцын мэдээ, жилийн эцсийн танилцуулгыг аймаг, нийслэлийн ЭМГ-аас авч нэгдсэн танилцуулга боловсруулсан. | 2024.06.01-2024.12.01 | |
| 4 | **Арга хэмжээ 2.2.** ОЭМҮХөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.2.4 Ундны усны чанар, аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх | Хяналт шалгалтын үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | - | 40% | Шинжилсэн дээжийн тоо- 1950 Шаардлага хангаагүй дээжийн хувь/ нян судлал- 9.6% Урьдчилан сэргийлэх шалгалтад нийслэл, аймаг, сумдын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн 48 | 2024.03.01-2024.11.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хяналт шалгалт зохион байгуулна. | | | | гүний худаг, 9 насос станц, 179 зөөврийн ус түгээх байр, 204 шугамаар ус түгээх байр, 510 ус хангамжийн төвлөрсөн сүлжээний хэрэглэгч, 724 сумдын худаг, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний 129 худаг, төвлөрсөн бус ус хангамжтай 75 хэрэглэгч, 6 ус зөөврийн машин 6, 15 гадаргын ус зэрэг 1950 обьектыг хамруулан нийт 3601 усны дээж авч, лабораторид шинжлүүлэн үнэлгээ өгөв. Шинжлэгдсэн нийт дээжийн 9.7% нь нянгийн бохирдолтой дүгнэгдсэн. Нянгийн бохирдлын түвшин өмнөх оныхоос 0.9%-иар буурсан үзүүлэлттэй байна. | | |
| | **Дэд арга хэмжээ.2.2.1** Шалгалтын удирдамж боловсруулж, аймаг, нийслэлийн ЭМГ-т хүргүүлнэ. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | 10% | Ундны усны чанар, аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай 10-00/20 дугаартай удирдамж боловсруулж хүргүүлсэн. | | |
| | **Дэд арга хэмжээ.2.2.2** Ундны усны 10 обьектод хяналт шалгалт хийж, усны дээж авч шинжлүүлэн үнэлгээ дүгнэлт өгнө. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | 25% | Архангай аймгийн 2 сумын ундын усны 2 худагт хяналт шалгалт хийж, 4 усны дээж, Улаанбаатар хотын Туул голын усны 8 цэгээс 16 дээж авч СХЗГ-ын Нийслэлийн лабораторид шинжлүүлсэн. Усны шинжилгээний дүнг үндэслэн улсын байцаагчийн 2 дүгнэлт, 2 албан шаардлага хүргүүлсэн. | | |
| | | Обьектын хамралтын хувь | 100% | 100% | | | |
| | **Дэд арга хэмжээ.2.2.3** Шалгалтын явц, жилийн эцсийн дүн мэдээг аймаг, нийслэлээс авч нэгдсэн танилцуулга | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | 25% | Шалгалтын явцын дүн мэдээг аймаг, нийслэлийн ЭМГ-аас авч нэгдсэн танилцуулга боловсруулсан. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсруулна. | | | | | | |
| 5 | **Арга хэмжээ 2.3.** ОЭМҮХөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.2.7 Ахуйн болон урьдчилан цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа, бохир ус цэвэрлэгээний түвшинд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийнэ. | Хамрагдсан обьектын тоо | 11 | 48 | | 2024.03.01-2024.11.30 | 100 |
| | | Стандартын шаардлага хангаагүй дээжийн эзлэх хувь/нян судлал | 48% | 47% | Стандартын шаардлага хангаагүй дээжийн эзлэх хувь 40%. Нийслэл, 17 аймгийн ахуйн бохир ус цэвэрлэх 39 байгууламж, 9 хүнсний үйлдвэрийн хаягдал ус урьдчилан цэвэрлэх 9 байгууламжид урьдчилан сэргийлэх шалгалт хийж, нийт хаягдал усны 150 дээж авч хими, нян судлалын лабораторид шинжлүүлэв. Нян судлалын лабораторид хаягдал усны 45 дээж шинжлүүлсэний 18 дээжинд (40%)-д гэдэсний бүлгийн нян илэрсэн. Шалгалтын явцад нийт 75 зөрчил дутагдал илрүүлэн, улсын байцаагчийн 41 заалттай 10 албан шаардлага, 6 заалттай 2 зөвлөмж хаягдал усны шинжилгээний талаар улсын байцаагчийн 31 дүгнэлт хүргүүлж, Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу 2 аж ахуйн нэгжид 15000 мян.төгрөгийн торгууль ногдуулав. | | |
| 6 | **Арга хэмжээ 2.4.** ЭАТХ-ийн 5.3 Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, барилгын зураг төсөл зохиох, ашиглалтад оруулахад хийх эрүүл ахуйн урьдчилсан хяналт шалгалтыг зохион байгуулна. | Хяналт шалгалтын үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | - | 50% | Улсын хэмжээний шалгалтын дүн мэдээг нэгтгэж нэгдсэн танилцуулга боловсруулсан. Зураг төсөлд хяналт хийлгэх талаар 1360 хүсэлтийг хүлээн авч, 1303 зураг төсөлд улсын байцаагчийн дүгнэлт гаргаж баталгаажуулсан. Зураг төсөл, | 2024.01.02-2024.12.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | баримт бичгийн бүрдэл дутуу 37 зургийг албан бичгээр буцааж, эрүүл ахуйн шаардлага хангаагүй 20 зураг төсөлд шаардлага хангахгүй талаар улсын байцаагчийн дүгнэлт гаргаж хүргүүлсэн.<br>Барилга байгууламжийг шинээр ашиглалтад оруулах 304 удаагийн комисст гишүүнээр ажиллаж, 279 барилгыг ашиглалтад оруулахаар шийдвэрлэж, эрүүл ахуйн нөхцөл шаардлага хангаагүй, үүрэг даалгаврыг бүрэн биелүүлээгүй, барилга угсралтын ажлыг бүрэн дуусгаагүй 25 барилгыг ашиглалтад аваагүй. 27 аж ахуйн нэгж байгууллагад Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн 70.3 сая.төгрөгийн торгууль ногдуулсан. | | |
| | **Дэд арга хэмжээ 2.4.1** Шалгалтын удирдамж боловсруулж, аймаг, нийслэлийн ЭМГ-т хүргүүлнэ. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | | 10% | Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, барилгын зураг төсөл зохиох, ашиглалтад оруулахад эрүүл ахуйн урьдчилсан хяналт шалгалт хийх тухай 10-00/02 дугаартай удирдамж боловсруулж хүргүүлсэн. | - | |
| | **Дэд арга хэмжээ 2.4.2** Ирүүлсэн хүсэлтийн дагуу барилга байгууламж зураг төсөл зохиох, ашиглалтад оруулахад эрүүл ахуйн урьдчилсан хяналт хийж дүгнэлт гаргана. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | 40% | Барилгын зураг төсөлд эрүүл ахуйн дүгнэлт гаргуулах 56 албан бичгийг хүлээн авч, 52 улсын ахлах байцаагчийн дүгнэлт, 4 албан бичгээр хариу өгсөн. Зөрчил дутагдал арилгуулах 2 заалттай албан шаардлага хүргүүлж, зөрчил | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | гаргасан 1 аж ахуйн нэгжид 2500 мян.төг-ийн шийтгэл оногдуулж, барагдуулсан. | | |
| | | Шийдвэрлэлтийн хувь | 100% | 100% | Хүсэлтийг бүрэн шийдвэрлэсэн. | | |
| 7 | **Арга хэмжээ 2.5.** ЭАТХ-ийн 4.4, ОЭМҮХөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.2.8<br>Хот, суурин газрын хөрсний бохирдлын түвшинд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт зохион байгуулна. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | 50% | Улсын хэмжээнд нян судлалын лабораторид 223 хөрсний дээж шинжлэгдсэний 127 (56.9%) "цэвэр", 51 (22.8%) "бага бохирдолтой", 29 (13%) "дунд зэргийн", 16 (7.3%) "их бохирдолтой" түвшинд үнэлэгдсэн. 2023 оны үнэлгээтэй харьцуулахад цэвэр ангилалд хамаарах дээжийн хувь 21.9%-иар өсч, дунд зэргийн болон их бохирдолтой ангилалд хамаарах дээжийн хувь 18.1%-иар буурч, хөрсний нянгийн бохирдлын түвшин эрс буурсан. | 2024.03.01-2024.12.10 | 100 |
| | | Дээжийн тоо | 149 | 80 | 223 | | |
| | | Их, дунд бохирдолтой дээжийн эзлэх хувь | 38% | 37% | Шинжилсэн дээжийн тоо- 223<br>~~Дунд, их бохирдолтой дээжийн~~ эзлэх хувь- 21% | | |
| | **Дэд арга хэмжээ 2.5.1**<br>Шалгалтын удирдамж боловсруулж, аймаг, нийслэлийн ЭМГ-т хүргүүлнэ. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | 10% | Хот суурин газрын хөрсний бохирдлын түвшинд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай 10-00/29 дугаартай удирдамж боловсруулж хүргүүлсэн. | | 100 |
| | **Дэд арга хэмжээ 2.5.2**<br>Шалгалтын явц, жилийн эцсийн дүн мэдээг аймаг, орон нутгаас авч нэгдсэн танилцуулга боловсруулна. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | 40% | Улсын хэмжээний шалгалтын явцын болон жилийн эцсийн мэдээ, танилцуулгыг нэгтгэн боловсруулсан. | | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 8 | **Арга хэмжээ 2.6.** ТХШТХ-ийн $5^3$.1<br>Амралтын газар, аялал жуулчлалын бааз, зочид буудлын үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт зохион байгуулна. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | 50% | Амралтын газар, аялал жуулчлалын бааз, зочид буудал, дэн буудал зэрэг нийт 167 обьектыг шалгалтад хамруулж, нийт 660 зөрчил дутагдлыг илрүүлж, улсын байцаагчийн 569 заалттай 67 албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч, биелэлт 70%-тай хангагдаад байна. Улсын байцаагчийн 230 заалттай 24 зөвлөмж, 35 дүгнэлт хүргүүлж, Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн 2 аж ахуйн нэгжид 12000 мян.төгрөгийн шийтгэвэр ногдуулсан. | 2024.03.01-2024.12.10 | 100 |
| | **Дэд арга хэмжээ 2.6.1**<br>Урьдчилан сэргийлэх шалгалтын удирдамж боловсруулж, аймаг, нийслэлийн ЭМГ-т хүргүүлнэ. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | 10% | Зочид буудал, дэн буудал, амралтын газар, аялал жуулчлалын баазад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай 10-00/30 дугаартай удирдамж боловсруулж хүргүүлсэн. | | |
| | **Дэд арга хэмжээ 2.6.2**<br>Шалгалтын явц, жилийн эцсийн дүн мэдээг аймаг, орон нутгаас авч нэгдсэн танилцуулга боловсруулна. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | 40% | Шалгалтын явц, жилийн эцсийн дүн мэдээг аймаг, орон нутгаас авч нэгдсэн танилцуулга боловсруулж, Салбарын хяналтын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд оруулсан. | | |
| 9 | **Арга хэмжээ 2.7.** ТХШТХ-ийн $5^2$.1<br>Иргэн, ААН, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт | Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувь | 100% | 100% | Иргэнээс ирүүлсэн 2 өргөдөл гомдлын хүрээнд дангаар болон БХБЯ-ны СХГ-тай хамтарсан удирдамжаар төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж Даацын цамхаг ХХК-д хугацаатай албан шаардлагаар үүрэг өгсөн. Иргэний | 2024.03.01-2024.12.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хийнэ. | | | | өргөдөлд дурьдсан асуудлаар шинжилгээ хийлгэж, шинжилгээний дүнг үндэслэн хариу өгөхөөр бэлтгэж байна. | | |
| 10 | **Арга хэмжээ 2.8.** ЗГҮАХөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 2.1.12.2. Ундны ус, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах, аудит хийнэ. | Аудит хийсэн тоо | 2 | 2 | Эрүүл мэндийн дэд сайдын баталсан "Усны аюулгүй байдлын төлөвлөгөөний хэрэгжилтэд хөндлөнгийн аудит хийх тухай" удирдамжийн дагуу Баянхонгор, Говь-Алтай аймгийн төвд усны аюулгүй байдлын төлөвлөгөөний хэрэгжилтэд хөндлөнгийн аудит хийж, усны аюулгүй байдлын төлөвлөгөөний багийн гишүүдэд сургалт зохион байгуулж, Бууцагаан, Баян-Уул суманд ус хангамжийн тогтолцоонд эрсдэлийг тодорхойлж, усны аюулгүй байдлын төлөвлөгөөний төслийг боловсруулж, үйл ажиллагааны тайланг НЭМБГ-т хүргүүлсэн. | 2024.04.01-2024.10.30 | 100 |
| | | Усны аюулгүй байдлын төлөвлөгөөний төсөл боловсруулсан тоо | 2 | 2 | | | |
| **Зорилт 3. Хяналт шалгалтын ил тод, тэгш байдлыг хангаж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.** | | | | | | | |
| 11 | **Арга хэмжээ 3.1.** Шинэчлэгдсэн стандарт, дүрмийн талаар аймаг, нийслэлийн байцаагч нарт онлайн сургалт зохион байгуулна. | Сургалтын тоо Хамрагдсан улсын байцаагчийн тоо | - | 1 цахим сургалт/ 43 байцаагч | Батагдсан хөтөлбөрийн дагуу "Хот суурин газрын хөрсний дээжинд эрүүл зүйн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх" сэдэвт цахим сургалтыг 2024.06.11-ний өдөр зохион байгуулсан. | 2024.03.01-2024.12.10 | 100 |
| **Зорилт 4. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллана.** | | | | | | | |
| 12 | Харьяа дээд шатны албан тушаалтныг асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргахад нь хуульд нийцсэн, баримт нотолгоонд тулгуурласан үнэн | Баримт, мэдээллийн тоо | - | Мэдээллээр хангасан байна. | Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналт шалгалтын үйл ажиллагаанд эрүүл ахуйн лабораторийн хэрэгцээ шаардлагын талаар танилцуулга | 2024.01.02-2024.12.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зөв мэдээлэл, мэргэшлийн зөвлөгөөгөөр хангасан байна. | | | | бэлтгэж газрын удирдлагад танилцуулсан.<br>Орчны эрүүл ахуйн хяналтын чиглэлээр 2023 онд хийсэн хяналт шалгалтын дүн мэдээллийг СХГ-ын тайланд тусгаж, Удирдлагын зөвлөлийн 2024.04.05-ны хуралд хэлэлцүүлж, хурлын шийдвэрийн дагуу БХБЯ-нд 2 албан бичгээр санал хүргүүлсэн.<br>БХБЯ-наас зохион байгуулсан Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хэсгийн хуралд 4 удаа оролцож, 2023 онд хийсэн үйлдвэрийн хаягдал усны хяналт шалгалтын дүнгийн талаар мэдээлэл танилцуулсан.<br>Дэлхийн усны өдрийг тохиолдуулан МҮОНТВ-ийн "Ундны усны чанар, аюулгүй байдал-эрүүл мэнд" сэдэвт шууд хэлэлцүүлэгт оролцсон.<br>Засгийн газрын ХХГ-ын Дахин инженерчлэлийн багийн гишүүнд шаардлагатай мэдээ мэдээллийг өгсөн.<br>СХГ-аас гадаад орчны агаарын чанар, шахмал түлшний чанарт хяналт хийх эсэх, тавьж буй хяналтын талаар тайлбар бэлтгэж, СХГ-ын даргад танилцуулсан.<br>Лабораторийн шинжилгээний асуудал орон нутагт тулгамдаж байгааг шийдвэрлүүлэх талаар | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | СХЗГ-ын даргад албан бичиг явуулж, аймгийн СХЗХ-т чиглэл өгүүлсэн.<br>ТНБД-ын өгсөн үүргийн дагуу ГБХНХЯ-ны Салбарын хяналтын газарт хүсэлт гаргаж, тус яамны 1-р давхрын албан хаагчдын өрөө тасалгаанд ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээний дүгнэлт гаргуулсан. | | |
| 13 | Төрийн үйлчилгээг шуурхай хүргэх, Архив, бичиг хэргийн хөтлөлтийн тухай, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, Авлигын эсрэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан байна. | Албан бичиг, өргөдлийн шийдвэрлэлтийн хувь | 100% | 100% | Хүлээн авсан нийт албан бичиг 104.<br>Үүнээс хариутай 67<br>Өргөдөл 2.<br>Ирүүлсэн хүсэлтэд улсын ахлах байцаагчийн 52 дүгнэлт, 15 хүсэлтэд албан бичгээр, 2 өргөдлийн дагуу хяналт шалгалт хийж, холбогдох газарт албан шаардлага өгч, хувийг иргэнд хүргүүлсэн. | 2024.01.02-2024.12.10 | 100 |

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (Биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Орчны эрүүл ахуйн хяналтын чиглэлээр холбогдох ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллана. | | | Ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж, хариуцсан үүрэг даалгаврыг биелүүлнэ. | 1) Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрт дүн шинжилгээ хийж, санал боловсруулах ажлын хэсэг,<br>2) Засгийн газрын 53 дугаар тогтоолоор батлагдсан Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх салбар дундын ажлын хэсэг, | 2024.01.02-2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 3) ЭМС, БОАЖСайдын 2023 оны А/482/А/657 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан Ус, ариун цэврийн байгууламжийн болон Уур амьсгалын өөрчлөлтийн ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж, ажлын хэсгийн хуралд оролцож, холбогдох санал өгч ажилласан.<br>4) ДЭМБ-тай хамтран зохион байгуулсан "Эрүүл мэндийн төлөөх шийдэл" санаачлага сэдэвт салбар дундын уулзалт-хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын хэсэг,<br>5) "Ус ариун цэвэр, эрүүл ахуйн тогтолцооны дэлхийн дүн шинжилгээ, үнэлгээ" хийх ажлын хэсэгт ажилласан. | | |
| 2 | Санал авахаар ирүүлсэн дүрэм, журам, стандартын төсөлд санал өгнө. | | | | 1 хууль, 3 журам, 3 стандартын төсөлд санал хүргүүлсэн. Үүнд:<br>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, "Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, санхүүжүүлэх, төлбөртэй тусламж, үйлчилгээний төрөл, орлого, хандив тусламжийг зарцуулах журам" батлах Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалын төсөл, Байгалийн гаралтай цацраг идэвхит материалтай холбоотой үйл ажиллагаанд цацрагийн мониторинг хийх журам, барилгын дотор заслын материалаас ялгарах хортой бодист түргэвчилсэн аргаар шинжилгээ хийх лабораторийн үзүүлэлт тоног төхөөрөмж сонгох журам, "Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага" MNS 4586:202..-ын төсөл, "Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын | 2024.01.02-2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сүлжээнд нийлүүлэх бохир ус. Ерөнхий шаардлага" MNS 6561:2024, Дотор орчны агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS стандартын төсөл болон СХГ-аас 2025 онд хийх хяналт шалгалтын үйл ажиллагааны төсвийн төсөлд тус тус санал боловсруулж хүргүүлэв. | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (Биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | **Арга хэмжээ 1.** Төрийн албан хаагчийг чадваржуулах богино хугацааны сургалтад хамрагдана. | Гэрчилгээ | - | Сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан, шинэ мэдээлэл олж авсан байна. | 1)Мянганы сорилтын сангаас зохион байгуулсан "Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх гарын авлага боловсруулах зөвлөх үйлчилгээ" сургагч багш бэлтгэх сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан.<br>2) Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 53 дугаар тогтоолоор баталсан "Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө"-ний хүрээнд Японы ЖАЙКА байгууллагаас зохион байгуулсан "Үйлдвэрийн урьдчилан цэвэрлэх байгууламжид хаягдал усыг цэвэрлэх" сургалтад Япон улсад 10 хоног хамрагдаж, гэрчилгээ авсан.<br>3) Улаанбаатар хотын үйлдвэрлэлийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төслийн багаас зохион байгуулсан 2 талбарын сургалтад хамрагдсан.<br>4) ЗГХЭГ-аас зохион байгуулсан "Процессын дахин инженерчлэл", ТАЗ-ийн "Байгууллага, хувь хүний санхүүгийн төлөвлөлт, удирдлага цахим | 2024.01.02-2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сургалт", АТГ-ын "Авлигын эсрэг хууль", ОБЕГ-ын "Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх тохиолдсон үед арга хэмжээ", Төрийн албаны шинэтгэл ба цэгцрэх хөдөлгөөн, Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа, Төрийн албан хаагчийн тасралтгүй хөгжих, гадаад улсын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах боломж үр дүн зэрэг сэдэвт 11 төрлийн цахим сургалт, ТЗУГ-аас зохион байгуулсан "Монгол Улсын эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүтэй байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох нь" сургалтад тус тус хамрагдсан. | | |
| 2 | **Арга хэмжээ 2.** Орчны эрүүл ахуйн хяналтын чиглэлээр судалгааны ажил хийнэ. | Судалгааны ажлын өгөгдөлд боловсруулалт хийж, тайлан бичих | | | Улаанбаатар хотын ундны усны эрүүл ахуйн үнэлгээ сэдэвт судалгаа хийж, усны шинжилгээний өгөгдөлд боловсруулалт хийж, тезисийн төслийг боловсруулсан. | | |

ТАЙЛАН ГАРГАСАН:
Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч (signature) (Б.Золбоо) 2024.12.05